

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.РОЗА ТАНАА

2024.08.23 № 281
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, санхүүгийн тайлан дахь 547.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6 гэсэн заалтууд болон УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн өмч хөрөнгийн бүртгэл тооллого, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

00402219

Аудитын гол асуудал

Сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>213,236,322.07</u>	<u>393,449,987.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	64,277,457.80	193,923,105.56
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	64,277,457.80	193,923,105.56
31110	Төгрөг	64,277,457.80	193,923,105.56
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	2,323,213.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,323,213.10
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	32,175,900.00	9,077,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	32,175,900.00	9,077,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	116,782,964.27	188,126,669.05
354	Хангамжийн материал	116,782,964.27	188,126,669.05
35410	Бичиг хэргийн материал	5,139,500.00	7,624,300.00
35420	Аж ахуйн материал	3,538,000.00	3,538,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	360,000.00
35460	Хүнсний материал	2,896,000.27	54,785,606.05
35470	Бусад хангамжийн материал	105,209,464.00	121,818,763.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,996,094,198.92</u>	<u>4,244,918,494.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,996,094,198.92	4,244,918,494.49
392	Биет хөрөнгө	3,935,590,032.27	4,183,101,088.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,125,740,126.00	4,296,533,384.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(527,335,527.40)	(591,287,386.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,000,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	287,652,429.07	396,153,929.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(182,892,186.80)	(192,923,106.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	200,865,291.00	264,825,291.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,553,787.35)	(139,414,734.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	148,491,890.00	148,491,890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(55,776,294.75)	(67,504,847.81)
39217	Ном	59,398,092.50	68,226,669.38
393	Биет бус хөрөнгө	<u>60,504,166.65</u>	<u>61,817,405.61</u>

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39301	Програм хангамж	550,000.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(45,833.35)	(155,833.39)
39303	Бусад биет бус хөрөнгө	60,000,000.00	60,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,209,330,520.99</u>	<u>4,638,368,482.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>173,044,184.03</u>	<u>229,016,663.32</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	173,044,184.03	229,016,663.32
413	Өглөг	173,044,184.03	229,016,663.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,880,767.03	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	160,163,417.00	229,016,663.32
41361	Байгууллагад төлөх өглөг	160,163,417.00	229,016,663.32
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,036,286,336.96</u>	<u>4,409,351,818.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,036,286,336.96	4,409,351,818.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	957,261,982.90	957,261,982.90
51101	Өмч: - төрийн	957,261,982.90	957,261,982.90
51102	- хувийн	-	-
51103	- хувьцаат	-	-
51104	Халаасны хувьцаа	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	267,864,709.95	640,930,191.87
51210	Өмнөх үеийн үр дүн	267,864,709.95	267,864,709.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	373,065,481.92
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,811,159,644.11	2,811,159,644.11
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,209,330,520.99</u>	<u>4,638,368,482.20</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,123,180,349.40	4,917,756,573.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,000,000.00	239,904,073.88
120	Нийтлэг татварын бус орлого	12,000,000.00	239,904,073.88
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	1,500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	1,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,000,000.00	233,043,073.88
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	5,361,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,111,180,349.40	4,677,852,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,762,022,449.40	4,425,997,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,541,693,100.00	4,425,997,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	220,329,349.40	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,809,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,849,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	960,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	346,348,900.00	251,855,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346,348,900.00	251,855,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,892,601,516.46	4,544,691,091.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,892,601,516.46	4,544,691,091.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,748,546,115.52	4,405,278,091.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,804,395,140.90	3,276,207,018.73
210101	Үндсэн цалин	2,278,914,040.90	2,175,746,821.64
210102	Нэмэгдэл	410,862,200.00	897,187,370.19
210104	Урамшуулал	114,618,900.00	203,272,826.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,143,221.39	412,109,805.38
210201	Тэтгэврийн даатгал	233,388,879.60	278,561,105.38
210202	Тэтгэмжийн даатгал	6,581,293.00	33,387,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,065,034.00	26,709,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,945,428.79	6,677,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,162,586.00	66,774,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	283,081,582.00	319,248,246.32
210301	Гэрэл, цахилгаан	9,473,000.00	15,574,775.00
210302	Түлш, халаалт	273,608,582.00	303,673,471.32
2104	Хангамж, бараа материалын зардал	11,728,836.00	25,429,600.00
210401	Бичиг хэрэг	4,380,136.00	9,734,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,348,700.00	15,695,300.00
2105	Нормативт зардал	240,520,420.03	201,779,723.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,580,000.00	-
210502	Хоол, хүнс	237,940,420.03	201,779,723.22
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,918,608.00	10,112,700.00
210604	Урсгал засвар	2,918,608.00	10,112,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,375,000.00	12,998,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,375,000.00	12,998,000.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,383,307.20	147,392,998.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,022,492.00	36,559,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,750,350.00	6,151,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,610,465.20	104,682,278.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,055,400.94	139,413,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,292,950.00	139,413,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,292,950.00	139,413,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	762,450.94	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	762,450.94	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>230,578,832.94</u>	<u>373,065,481.92</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>230,578,832.94</u>	<u>373,065,481.92</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,892,851,000.00</u>	<u>4,679,352,500.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,000,000.00	1,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,000,000.00	1,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	1,500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	1,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,890,851,000.00	4,677,852,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,541,693,100.00	4,425,997,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,541,693,100.00	4,425,997,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,809,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,849,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	960,000.00	

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	346,348,900.00	251,855,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346,348,900.00	251,855,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,768,573,542.20</u>	<u>4,452,690,252.24</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,768,573,542.20	4,452,690,252.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,619,324,491.26	4,313,277,252.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,735,827,639.20	3,286,180,604.24
210101	Үндсэн цалин	2,210,346,684.90	2,187,143,307.15
210102	Нэмэгдэл	410,862,114.30	897,187,430.19
210104	Урамшуулал	114,618,840.00	201,849,866.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	340,829,956.06	417,340,200.00
210201	Тэтгэврийн даатгал	231,993,256.98	283,791,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,210,000.00	33,387,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,767,899.78	26,709,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,438,999.59	6,677,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	54,419,799.71	66,774,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,226,000.00	250,755,000.00
210301	Гэрэл, цахилгаан	9,473,000.00	15,574,775.00
210302	Түлш, халаалт	165,753,000.00	235,180,225.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	
2105	Нормативт зардал	236,648,670.00	260,933,328.00
210502	Хоол, хүнс	236,648,670.00	260,933,328.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,518,500.00	14,634,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,518,500.00	14,634,320.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,173,726.00	82,333,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,429,930.00	67,465,440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,743,796.00	14,868,360.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,249,050.94	139,413,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	148,486,600.00	139,413,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	148,486,600.00	139,413,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	762,450.94	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	762,450.94	
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>124,277,457.80</u>	<u>226,662,247.76</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,000,000.00	97,016,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,000,000.00	97,016,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,000,000.00	97,016,600.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,000,000.00	97,016,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(60,000,000.00)</u>	<u>(97,016,600.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	64,277,457.80	129,645,647.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		64,277,457.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,277,457.80	193,923,105.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,824,479,307.11	139,234,203.50	3,920,975,493.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын			13,319,663.00	13,319,663.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	957,261,982.90	2,824,479,307.11	152,553,866.50	3,934,295,156.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,				-
C07	Тайлант үеийн үр дүн		(13,319,663.00)	115,310,843.45	101,991,180.45
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	267,864,709.95	4,036,286,336.96
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	267,864,709.95	4,036,286,336.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	267,864,709.95	4,036,286,336.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			357,873,919.10	357,873,919.10
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	625,738,629.05	4,394,160,256.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,742,130,000.00	4,549,706,852.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,742,130,000.00	4,549,706,852.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,584,414,500.00	4,410,293,852.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,419,778,500.00	3,287,603,564.24
210101	Үндсэн цалин	2,251,180,700.00	2,187,143,307.15
210102	Нэмэгдэл	953,660,600.00	897,187,430.19
210104	Урамшуулал	214,937,200.00	203,272,826.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	427,472,100.00	417,340,200.00
210201	Тэтгэврийн даатгал	290,681,100.00	283,791,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	34,197,700.00	33,387,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,358,200.00	26,709,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,839,500.00	6,677,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	68,395,600.00	66,774,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,755,000.00	250,755,000.00
210301	Гэрэл, цахилгаан	12,473,000.00	15,574,775.00
210302	Түлш, халаалт	238,282,000.00	235,180,225.00
2105	Нормативт зардал	293,670,800.00	267,233,328.00
210502	Хоол, хүнс	293,670,800.00	267,233,328.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,923,600.00	16,734,020.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,923,600.00	16,734,020.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,714,500.00	169,527,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,329,100.00	144,142,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,385,400.00	25,385,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,715,500.00	139,413,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	157,715,500.00	139,413,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	157,715,500.00	139,413,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,677,852,500.00	4,679,352,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,425,997,500.00	4,425,997,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,425,997,500.00	4,425,997,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	251,855,000.00	251,855,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	251,855,000.00	251,855,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,500,000.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		64,277,457.80
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		193,923,105.56
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	199	202
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	116	118
620003	Үйлчлэх ажилтан	82	83
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	199	202
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	117	119
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	82	83

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,809,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,809,000.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,809,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,809,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,809,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,809,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,809,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,849,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	960,000.00	
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм..

Тайлант оны зорилго: “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж , боловсролын үйлчилгээний хүртээмж , чанарт ахиц гаргах”

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- I. Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд сурталчлан таниулах , тэдний оролцоотой хэрэгжүүлэх
- II. Алслагдсан багт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт , үйл ажиллагаагаар дэмжих
- III. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх,арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх,сурлагын амжилтад ахиц гаргах
- IV. Багшийн хөгжлийг дэмжих , ажлын байранд хөгжих нөхцөл бололцоогоор ханган , бусад сургуулиудын сайн туршлагуудыг судлах
- V. Англи хэлний Pearson хөтөлбөр , бага ангийн математикийн Editen хөтөлбөрийн анги тохижуулалт , багш нарын арга зүй, суралцагчийн ур чадварт ахиц гарган ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузел суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас тайлант онд тус сургуулийн 2021, 2022 оны санхүүгийн үйл

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар акт тогтоогдоогүй, албан шаардлага өгөгдсөн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 429.0 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	64,277.46	193,923.11	129,645.65
Авлага	-	2,323.21	2,323.21
Урьдчилж гарсан зардал	32,175.90	9,077.00	(23,098.90)
Бараа материал	116,782.96	188,126.67	71,343.70
Нөөцийн бараа			-
Үндсэн хөрөнгө	3,996,094.20	4,244,918.49	248,824.30
Нийт хөрөнгө	4,209,330.52	4,638,368.48	429,037.96

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөр	173,044.18	229,016.66	55,972.48
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,036,286.34	4,409,351.82	373,065.48
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,209,330.52	4,638,368.48	429,037.96

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал дансуудад бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 129.6 сая төгрөг болж оны эхнээс 7.0 сая төгрөгөөр өссөн нь байна. Үүний 142.3 сая төгрөг нь цалин хөлс, 26.4 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардал, 23.7 сая төгрөг нь бусад зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй, оны эцэст 2.3 сая төгрөгийн авлагатай гарсан нь илүү шилжүүлсэн цалингийн ашгийн авлага байна.

Бараа материалын данс 71.3 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлээс хоол, бичиг хэрэг, бусад хангамжийн материалыг үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Үүнд: аж ахуйн материалын үлдэгдэл 3.5 сая, бичиг хэрэг 7.6 сая, түлш 0.3 сая хүнсний материал 54.8 сая, бусад хангамжийн материал 121.8 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгийн данс 258.1 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 115.6 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 278.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 136.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,244.9 сая төгрөг болж 248.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 120.5 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 233.0 сая нийт 353.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 21.0 сая төгрөгийн автомашиныг аймгийн ОНӨГ-ын шийдвэрээр акталж, 104.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд БШУЯ-наас үнэ төлбөргүй хүлээн авсан 1350.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8480.6 сая төгрөгийн ном, 5361.0 мянган төгрөгийн аж ахуйн материал нийтдээ 15191.6 мянган төгрөгийн санхүүгийн тайланд тусгаж ирүүлээгүйг байсныг залруулсан.

Өглөг дансны оны эхний түлш халаалтын өглөг барагдаагүй, оны эцэст шинээр 56.0 сая төгрөгийн түлш халаалтын өглөг нэмэгдэж 229.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан. Жил бүр халаалтын өглөг дутуу батлагддаг гэсэн тайлбарыг өгч байна.

Тайлант онд 373.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 373.1 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн өмнө нь ажиллаж байсан захирал, нягтлан бодогч нар ажлаас гарсан тул дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн 2023 оны төсвийн төслийг боловсруулсан тоо баримт, мэдээлэл олдоогүй болно.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сургуулийн 2023 оны төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4426.0 сая төгрөгөөр, оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэх дүнг 64.2 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 251.9 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт оруулаагүй байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,426.0 сая, орон нутгийн төсвөөс 251.9 сая нийтдээ 4,679.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 64.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,549.7 сая төгрөг буюу 95.9 хувьтай дансанд 193.9 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	6,769.40	6,769.40	-	100.0
2	80312	Сургалт семинар	4,051.10	4,051.10	-	100.0
3	81605	Эрүүл мэндийг дэмжих	6,769.40	6,020.15	749.25	88.9
4	81801	Үдийн цай хөтөлбөр	157,715.50	139,413.00	18,302.50	88.4
5	81806	Дотуур байрны үйлчилгээ	483,449.00	437,183.38	46,265.62	90.4
6	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	76,379.90	75,475.00	904.90	98.8
7	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	17,629.60	14,504.00	3,125.60	82.3
8	81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	40,249.90	40,035.74	214.16	99.5
9	81834	Боловсролын стандарт, сургалт	2,715,649.60	2,600,364.58	115,285.02	95.8
10	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	981,611.60	974,035.50	7,576.10	99.2
11	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	251,855.00	251,855.00	-	100.0
Нийт дүн			4,742,130.00	4,549,706.85	192,423.15	95.9

Эх сурвалж: Аудитын хийсэн ТГТайлан

Сургуулийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 95.9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалин, НДШ-ийн зардал 142.3 сая, хоолны норматив зардал 26.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 23.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 442.7 сая төгрөгийн бараа материал, 120.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,892.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 25.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын FAS программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг шалгахад 2,162.3 сая төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 358.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Сургуулийн захирлын төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай холбоотой албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгох, балансын урамшуулал олгох тухай 3.3 сая төгрөгийн 4 тушаал тушаалын гүйлгээг шилэн дансанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,598.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.3 сая төгрөгийн акт, 1,595.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд актыг барагдуулж, 4 албан шаардлагын зөрчлийг бүрэн арилгаж, 1 зөвлөмж хэрэгжүүлж ажилласан. 1 албан шаардлага буюу 173.2 сая төгрөгийн зөрчил биелэгдээгүй шүүхийн шатанд явж байгаа хариу гараагүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	3,326.7	3	3,326.7	100%
Албан шаардлага	5	1,594,994.7	4	1421,795.5	89.1%
Зөвлөмж	1		1		100%
Нийт дүн	9	1,598,321.4	8	1,425,122.2	96.4%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул хөтөлбөр арга хэмжээний зардлууд болон төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,191.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд 15,191.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Залруулсан алдаа:

- Сургуулийн анх ирүүлсэн санхүүгийн тайланд БШУЯ-наас үнэ төлбөргүй хүлээн авсан 9,830.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 5,361.0 мянган төгрөгийн бараа материалыг тусгаагүй байсныг тайланд тусгуулан залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 559,734.1 мянган төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 559,734.1 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.Үүнд:

1. Баян-Өлгий аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 130/ШШ2023/00878 дүгээр шүүгчийн захирамжийн дагуу нярвын ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 2,562.5 мянган төгрөгийг сургуулийн төсвөөс олгож, төсөвт тусгагдаагүй зориулалт бусаар зардал гаргасан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөв.

2. Урамшууллын цалингийн төсвөөс 1422.9 мянган төгрөгийн, хоолны зардлын төсвөөс 6300.0 мянган төгрөгийн, мэдээлэл технологийн зардлын төсвөөс 2099.7 мянган төгрөгийн нийтдээ 9,822.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцах дансны эхний үлдэгдлээс худалдан авч төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөв.

3. Сургуулийн захирлын 2023 оны А/60 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн хөрөнгө, бараа материалын тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хагас дутуу хөтөлсөн, тооллогын дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл 547,348.9 мянган төгрөгийн хөрөнгийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим", 5.1 дэх хэсэг, "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2006 оны 388 дугар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар аргачлалын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үнэ төлбөргүй авсан хөрөнгийг дутуу тайлагнасан.	1	15,191.5			1	15,191.5	1	15,191.5				

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	1	15,191.5			1	15,191.5	1	15,191.5				
-----	---	----------	--	--	---	----------	---	----------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас төсөвт тусгагдаагүй зориулалт бусаар зардал гаргасан.	1	2,562.5			1	2,562.5						
Зардлын ангилал зөрчиж үндсэн хөрөнгийг бэлтгэсэн.	1	9,822.70			1	9,822.60						
Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	547,348.90			1	547,348.90						
Дүн	3	559,734.1			3	559,734.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								